



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРОО” ТӨААТҮГ-ЫН ДАРГА
А.ТЛЕЙХАН ТАНАА

2017.03.15 № 3/430
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО”ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахимхаяг:
sambuunyamyia@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахимхаяг: serjmyadagb@audit.gov.mn

АБ-ын хаяг: Ас-Арвай аудит ХХК
Утас: 99110691, 70115359
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.as-arvai.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8дахь зүйлийн 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дахь зүйлийн 15.1.2 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 18 дахь зүйлийн 18.3дахь заалтын дагуу Монгол улсын Ерөнхий аудиторов бүрэн эрхийн хүрээнд “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/298/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийв.

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт/СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлагасанхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг манай компани 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөв.

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2017 оны 2 дүгээр сарын 03-нд Ас-Арвай аудит ХХК-нд ирүүлсэн болно.

Аудитыг 2017 оны 2 дугаар сарын 10-наас 2017 оны 03 дугаар сарын 09-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд байгууллагын удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын удирдлага нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компаний тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд үйл

ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт орсон. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдсөн.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

2001 онд шинэчлэгдэн батлагдсан Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах газар байгуулагдсан.

2011 оны 12-р сарын 09-ний өдөр УИХ-аас Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу Засгийн газрын 2012 оны 2-р сарын 15-ны өдрийн 49 дугаар тогтоолоор Эрчим хүчний зохицуулах газрыг “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ болгон өөрчлөн байгуулсан.

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чигүүргийг хэрэгжүүлнэ. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ хэрэгжүүлнэ. “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж байна.

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын үндсэн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Ажахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөрт тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө.”

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны хүрээнд зорилтот түвшингээ Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраар батлуулж, мөрдөж ажиллаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу СТОУС, Сангийн сайдын 77 дугаар тушаалд нийцэх НББ-ийн Винница програмаар боловсруулж санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Материаллаг байдал:

Урьд оноос үндсэн хөрөнгө 76,2 сая төгрөг, авлага 624,2 сая төгрөгөөр өсч нийт хөрөнгө тайлант онд 418,2 сая төгрөгөөр өсч 2,730.3 сая төгрөгт хүрсэн. Материаллаг байдлыг нийт хөрөнгийн 1.0 хувь 27.3 сая төгрөгөөр тогтоолоо. /ТАБ-СТА-А-2/. Агуулгын хувьд буюу шинж чанарын хувьд материаллаг аливаа зүйл байхгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "Эрчим хүчний зохицуулах хороо" ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Шилэн дансны мэдээлэл

"Эрчим хүчний зохицуулах хороо" ТӨААТҮГ нь 2014 оны 7 дугаар сарын 1-нд шилэн дансны хууль батлагдсантай холбоотойгоор 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс Shilendans.gov.mn сайтад өөрийн сервирийг үүсгээд мэдээлэлээ оруулж эхлээд байна. Шилэн дансны хуулинд заагдсан мэдээлэлийг хавсралтад дурдсан хугацаанд байнга оруулж байгаа.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

"Эрчим хүчний зохицуулах хороо" ТӨААТҮГ нь нийт 3,500.1 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс зохицуулах үйлчилгээний хөлсөнд 2,902.1 сая төгрөг, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон зохицуулах үйлчилгээний хөлсөнд 567.9 сая төгрөг орсон байна. Нийт төлөвлөсөн зардал 3,567.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 3,319.2 сая төгрөгийн зардал гарсан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 3,172.2 сая төгрөг, хөрөнгийн санхүүжилтанд 147.0 сая төгрөг зарцуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд бараа материалыг дансанд тусгаагүй анхан шатны баримт бүрдүүлээгүй 3,0 сая төгрөгийн зарлага гаргасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

2. Тус хорооны 15 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохиогдсон Онол практикийн бага хурлын шилдэг илтгэлүүдийн урамшуулалд олгосон 4,3 сая төгрөгнөөс ХХОАТ-ыг тооцож аваагүй байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”-оос татвар ноогдуулна гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна .

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хувь хүнд олгосон гэрээний дагуу гүйцэтгэсэн хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос татвар суутгаж харъяа татварын хэлтэст шилжүүлж байх зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2015оны тайланд дараахь 2 зөвлөмж өгсөн байна. 1. Эрчим хүчний тухай хуульд заасан Эрчим хүчний зохицуулах хороо, түүний бүрэн эрх, үүрэгтэй холбоотой зөрчилтэй заалтуудыг хуульд өөрчлөлт оруулах замаар санал боловсруулж холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх, 2. Жилийн эцсийн тооллогын бүртгэл, түүний үр дүнг хорооны зохицуулагчдын зөвлөл болон удирдлагын хурлаар авч хэлэлцэн шийдвэрлэн баталгаажуулж байх,

хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөнд тавих хяналтыг сайжруулах гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас хавсаргав.



**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО”
ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫСАНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Анхан шатны баримтын бүрдлийг
хангаж ажиллаагүй.

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

ХХОАТ-ыг тооцож суутгаагүй байна.

Менежментийн захидал

“Ас-Арвай аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрчим хүчний зохицуулах хороо” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Үндсэн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт</u> Тайлант хугацаанд бараа материалыг дансанд тусгаагүй анхан шатны баримт бүрдүүлээгүй 3,0 сая төгрөгийн зарлага гаргасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	<u>Зөвлөмж</u> Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.
<u>Эрсдэлүүд</u> Санхүүгийн тайланд бүртгэлээр тавих хяналт сул, үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.	<u>Төсвийн захирагчийн хариу</u> Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, хөрөнгийг орлогод авч зарлага гаргаж байна.

Асуудал 2: Татвар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт</u> Тус хорооны 15 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохиогдсон Онол практикийн бага хурлын шилдэг илтгэлүүдийн урамшуулалд олгосон 4,3 сая төгрөгнөөс ХХОАТ-ыг тооцож аваагүй байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”-оос татвар ноогдуулна гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна .	<u>Зөвлөмж</u> ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хувь хүнд олгосон гэрээний дагуу гүйцэтгэсэн хөдөлмөрийн хөлс,шагнал,нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос татвар суутгаж харъяа татварын хэлтэст шилжүүлж байхзөвлөмж хүргүүлэв.
<u>Эрсдэлүүд</u> Эрх үүрэг зөрчигдөх.	<u>Төсвийн захирагчийн хариу</u> ХХОАТ-ыг бүрэн суутгаж харъяа татварын хэлтэст шилжүүлж байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	466,080,653.62	166,659,577.20
1.1.2	Дансны авлага	313,393,497.01	937,564,737.51
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	801,029.26	206,036.49
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	42,577,968.58	63,465,674.62
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,165,055.90	176,491.46
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бvlлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	826,018,204.37	1,168,072,517.28
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,486,079,346.38	1,562,305,861.41
1.2.2	Биет бус хөрөнгө	0.00	0.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,486,079,346.38	1,562,305,861.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,312,097,550.75	2,730,378,378.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	19,061,828.00	11,378,828.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.20	0.00
2.1.1.3	Татварын өр	8,912,119.10	53,249,977.87
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	552,147,775.30	762,333,146.30
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	879,806.98	879,806.98

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	581,001,529.58	827,841,759.15
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	581,001,529.58	827,841,759.15
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	104,537,450.95	104,537,450.95
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	364,857,785.30	364,857,785.30
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	61,091,431.21	66,075,249.21
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,200,609,353.71	1,367,066,134.08
2.3.20	Эздийн өмчийн дүн	1,731,096,021.17	1,902,536,619.54
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2,312,097,550.75	2,730,378,378.69

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын	2,375,405,897.00	3,500,111,663.00
2	Борлуулалтын	0.00	0.00
3	Нийт ашиг (	2,375,405,897.00	3,500,111,663.00
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн	0.00	0.00
7	Улсын төсвийн	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт,	0.00	0.00
10	Ерөнхий ба	2,291,986,919.36	3,318,958,970.44
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын	0.00	622,582.74
14	Үндсэн хөрөнгө	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт	0.00	0.00
17	Бусад ашиг (	5,368,305.10	48,507,915.32
18	Татвар төлөхийн	88,787,282.74	230,283,190.62
19	Орлогын татварын	8,878,728.27	63,826,410.25
20	Татварын дараах	79,908,554.47	166,456,780.37
21	Зогсоосон үйл	0.00	0.00
22	Тайлант үеийн	79,908,554.47	166,456,780.37
23	Бусад дэлгэрэнгүй	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин	0.00	0.00
23.2	Гадаад валютын	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд	0.00	0.00

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016.12.31

[illegible]

13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	4,983,818.00	0.00	4,983,818.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	166,456,780.37	166,456,780.37
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	36,806,091.30
17	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	104,537,450.95	0.00	0.00	364,857,785.30	0.00	66,075,249.21	1,367,066,134.08	1,902,536,619.54

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,595,708,501.00	3,152,238,095.82
1.1.1	Бараа борлуулсан,	2,582,912,863.00	3,095,269,031.00
1.1.2	Эрхийн шимтгэл,	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	12,795,638.00	56,969,064.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,234,235,372.83	3,341,726,844.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,293,155,842.66	1,881,439,709.27
1.2.2	Нийгмийн даатгалын	286,203,808.63	382,670,731.59
1.2.3	Бараа материал худалдан	13,693,420.70	14,068,330.00
1.2.4	Ашиглалтын зардалд	27,548,585.25	35,677,054.70
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн	33,129,640.81	44,192,867.04
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад	147,897,216.00	206,184,796.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	59,400.00	15,232.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	432,547,458.78	777,478,124.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны	361,473,128.17	-189,488,749.16
2	Хөрөнгө оруулалтын үйл	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,158,629.58	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл,	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний	4,158,629.58	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-26,598,040.00	-410,554,910.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж	-26,598,040.00	-105,765,010.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж	0.00	-4,789,900.00
2.2.4	Бусад урт хугацаат	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл	-22,439,410.42	-110,554,910.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад орлого	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,209,675.52	622,582.74
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад зарлага	1,209,675.52	622,582.74
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны	1,209,675.52	622,582.74
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	340,243,393.27	-299,421,076.42
5	Мөнгө, түүнтэй адилтгах	125,837,260.35	466,080,653.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах	466,080,653.62	166,659,577.20